

ӨРГӨХ, ТЭЭВЭРЛЭХ ТӨХӨӨРӨМЖ АШИГЛАХ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компани /цаашид “ЭТТ” ХК гэх/-ийн Уурхайн бүсэд ашиглагдах оосорлох, өргөх тээвэрлэх болон зөөх төхөөрөмж /өөрөө буулгагч кран бүхий ачааны машин, кран болон бусад өргөх тоног төхөөрөмж, гар удирдлагатай механик багаж, данхраад, тусгай өргөх төхөөрөмж/-ийн аюулгүйн ажиллагааны харилцааг зохицуулахад энэ журмын зорилго оршино.

1.2. Энэхүү журам “ЭТТ” ХК-ийн уурхайн болон уурхайн бүсэд үйл ажиллагаа явуулж буй гэрээт болон туслан гүйцэтгэгч компани, тэдгээрийн ажилтанд нэгэн адил хамааран үйлчилнэ.

1.3. Энэхүү журамд тусгагдаагүй асуудлыг холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журам, ажлын горим, заавраар шийдвэрлэгдэнэ.

Хоёр. Өргөлт, оосорлолт, үйл ажиллагаа

2.1. Кран зогсох болон ачаа буулгах талбайн даацын хангалт, тэгш байх шаардлагыг хангаж буй эсэхийг оператор шалгана.

2.2. Оператор краны тулгуурыг стандартын дагуу тэгш байрлуулж, шаардлагатай бол зориулалтын ивүүр, дэр хийж өргөлтийн аюулгүй байдлыг хангана.

2.3. Оосорлогч нь ачааны тэнцвэрийг олж оосорлох үүднээс тэгш хэмгүй эсхүл нэг нийлмэл бүтэцтэй ачааг оосорлоход онцгой анхаарна.

2.5. Ачааны хурц ирмэгтэй хэсгээр татлагыг тааруулан оосорлож үл болно.

2.6. Татлагыг хамгаалалтын зөөлөвчгүйгээр хурц ирмэгтэй зүйл дээгүүр дамнуулан татах, ачаан доор оруулж газар дээгүүр шууд чирэх, угзрах зэргийг хориглоно.

2.7. Дэгээ, троссны залгааг хийхдээ ачааны өндөр, дээш өргөх зай, троссны гүйлт, зэргийг тооцож тохируулан оосорлоно.

2.8. Боломжтой бол түгжээтэй (мултрах аюулгүй) дэгээ хэрэглэнэ.

2.9. Өргөхөөс өмнө оосорлогч нь ачааны болон тросс, татлаганы аль нэгэн хэсэг суларсан болон түгжээ бэхэлгээ хийгдсэн байдлыг шалгаж баталгаажуулна.

2.10. Өргөх үйл ажиллагааны үед дор дурдсан зарчмыг мөрдлөг болгоно.

2.10.1. Өргөж буй ачааны доогуур орохгүй байх;

2.10.2. Өргөлт хийх талбайг бүрэн тусгаарлаж, хаалт тэмдэглэгээ хийх;

2.10.3. Мэргэжлийн сургалтанд сууж үнэмлэх гэрчилгээ авсан, ажлын болон аюулгүй ажиллагааны зааварчилгаа авсан хүнээр ажил хийлгэх;

2.10.4. Ажлын аюулын шинжилгээ хийж, танилцуулсаны дараа өргөх үйл ажиллагааг эхлүүлэх;

2.10.5. Өргөх үйл ажиллагаанд хамааралгүй ажилтан болон бусад хүмүүсийг ажлын талбайд оруулахгүй байх;

2.10.6.Өргөх, тээвэрлэх техникийн бүх хэсэг, татлага гинж, оосор зэрэг бүх хэрэгслийн бүрэн бүтэн эсэхийг шалгаж, гэмтэл, согог илэрвэл ажлыг даруй зогсоож ахлах ажилтанд мэдэгдэх;

2.10.7.Зөвхөн нэг хүний дохиогоор өргөлтийг зохицуулах зэрэг болно.

Гурав. Ачааны жин болон техникийн даац

3.1.Өргөлтийн даацын хязгаарыг тогтоохдоо техникийн хэрэгслийн хэсэг, эд анги тус бүрийн даацыг шалгаж, хамгийн бага даацтайгаар нь авна.

3.2.Өргөх ачааны жинг тогтоохдоо бүх материалын нийлбэр жинг тооцно. Түүнчлэн өргөхөд нэмэлтээр ашиглах хэрэгслийн жинг нэмж тооцно.

3.3.Даацыг тогтоохдоо үйлдвэрийн тэмдэглэгээ, баталгааны баримт, дардас, шошго, гарын авлага зэргийг ашиглаж шаардлагатай мэдээллээ авч болно.

Дөрөв. Өргөх тээвэрлэх төхөөрөмж, татлага, тросс

4.1.Аливаа өргөх ажиллагаанд хэрэглэх бүх татлага, троссны даац тодорхой байх шаардлагатай бөгөөд оператор үүнийг шалгасан байна.

4.2.Краны оператор өргөх ажиллагаа бүрийн өмнө болон дараа бүх тоног хэрэгслийг үзэж шалгахдаа дараах зүйлд анхаарч ажиллана.

4.2.1.Үрэгдэж холгогдсон, сунасан хэсэг байгаа эсэх;

4.2.2.Троссны сэмэрхий буй болсон эсэх;

4.2.3.Зүсэгдсэн сэтэрхий болон нүх эсхүл цууралтүүссэн эсэх;

4.2.4.Бохирдсон эсвэл шороо тоос чихсэн, элэгдсэн эсэх;

4.2.5.Дэгээ гэмтсэн эсэх;

4.2.6.Шошго, дардас нь байхгүй эсхүл арилж баларсан эсэх зэрэг болно.

4.3.Бүх татлага, троссыг газраас хөндийрүүлэн зориулалтын дэгээнд өлгөж хуурай цэвэр хадгална.

4.4.Аливаа кран, өргөх төхөөрөмжийг ашиглахын өмнө оператор болон мэргэжлийн хүн техникийн үзлэг хийж аюулгүй болохыг шалгаж баталгаажуулсан байна.

Тав. Өргөх тээвэрлэх төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа

5.1.Дор дурдсан нөхцөлөөр буву хэвийн бус, эрсдэлтэй өргөлт хийхийг хориглоно.

5.1.1.Хоёр ба түүнээс олон кранаар ачааг зэрэг өргөхийг;

5.1.2.Ямар нэг өргөх төхөөрөмжийг крантай хамт ашиглахыг;

5.1.3.Краны ажлын аюулгүйн хязгаар (аах) буюу баталгаат даацын наян (80%) хувиас хэтэрсэн ачаа өргөхийг тус тус хориглоно.

5.2.Хэвийн бус, эрсдэлтэй өргөлт хийх зайлшгүй шаардлага гарвал өргөлтийг удирдах ажилтан нь өөрийн багийн хамт ажлын аюулын шинжилгээ (ааш) хийж, дор дурдсан үзүүлэлтийг багтаасан өргөх нарийвчилсан төлөвлөгөө гаргана.

5.2.1.Ачааны нийт жин болон кран, тоноглолын даац;

5.2.2.Ачааны тэнцвэр, бэхэлгээний цэг;

5.2.3.Өргөх талбайн нөхцөл;

5.2.4.Ажилтны мэргэжлийн ур чадвар болон үүрэг хариуцлага;

5.2.5.Бүх зай хэмжээ зэрэг болно.

Зургаа. Үүрэг, хариуцлага

6.1. Өргөх тээвэрлэх үйл ажиллагаатай холбогдуулан холбогдох ажилтан дор дурдсан үүрэг, хариуцлагыг хүлээнэ.

6.1.1.Өргөх үйл ажиллагааг хэрхэн аюулгүй хийж гүйцэтгэх талаар уурхайн холбогдох журам, өргөх үйл ажиллагааны схем (ett-fc05-a1)-ын дагуу урьдчилан төлөвлөгөө гаргаж, давхар шалгах;

6.1.2.Өргөх ажиллагааг төлөвлөн эрсдлийн үнэлгээ хийж ажилтан бүр түүнтэй танилцаж, гарын үсгээр баталгаажуулах;

6.1.3.Өргөх ачааны жингийн хэмжээ өргөх техник хэрэгслийн даацтай тохирч байгаа эсэхийг шалгах;

6.1.4.Өргөх талбайд урьдчилсан үзлэг хийж зөөх замд гулгах, халтирах мөн суух, шигдэх аюул байгаа эсэхийг шалгаж талбайг тусгаарлах, шаардлагатай тохиолдолд цэвэрлэгээ хийх, ажлын талбайг засаж цэгцлэх зэрэг арга хэмжээг авах;

6.1.5.Өргөх, дохих, чиглүүлэх, оосорлох хүн бүр өргөх ажиллагааны талаар мэдлэг эзэмшсэн, мэргэжлийн сургалтанд хамрагдаж үнэмлэх, гэрчилгээ авсан байх;

6.1.6.Өргөх ажиллагаанд оролцох хүний тоо хангалттай байх ёстой бөгөөд хэн нэг хүний үүргийг давхар гүйцэтгэхгүй байх;

6.1.7.Оосорлогч болон дохиочин ажлаа давхар хийх, түр орхиж жирийн ажилтнаар түр орлуулан гүйцэтгүүлэхгүй байх;

6.1.8.Өргөх ажиллагааг эхлүүлэхийн өмнө цаг агаарын урьдчилсан мэдээг заавал авч цаг агаарын байдал муудах, салхины хурд ихсэх үед өргөх ажиллагааг хойшлуулах;

6.1.9.Ажлын талбайг байнга чөлөөтэй байлгах; /Үүнд ачаанаас гадна краны сум болон эсрэг жингийн эргэлтийн радиус мөн хамаарна/

6.1.10.Краны оператор болон дохиочин тасралтгүй найдвартай холбоогоор хангагдсан байх;

6.1.11.Өргөх ажиллагааг эхлүүлэхийн өмнө гараар өгөх дохиог багаараа ярилцаж, 1 удаа сургуулилсан байх;

6.1.12.Өргөх ажиллагаанд оролцож буй ажилтан бүр өгч буй дохионы илэрхийллийг бүрэн ойлгож мэдсэн байх;

6.1.13.Өргөлтийн үед нөхцөл байдал өөрчлөгдөж магадгүй тул оролцож байгаа бүх ажилтан орчноо бүрэн хяналтандаа байлгаж байнга шалгахзэрэг болно.

Долоо. Бусад

7.1.Компанийн ерөнхий механик уурхайд ашиглагдаж буй бүх өргөх механизм болон тоног төхөөрөмжийг бүртгэж, хадгалах үүргийг хэрэгжүүлж, энэ журмын 1 дүгээр хавсралтад заасны дагуу өргөх тээвэрлэх төхөөрөмжийн үзлэг шалгалтыг хийнэ.

7.2.Бүртгэлд төхөөрөмжийн төрөл (бүх тоног төхөөрөмж тод харагдахуйц хувийн дугаартай байна), уурхайн хаана хэрэглэгдэж байгаа, хэзээ хамгийн суулд (шаардлагын дагуу) шалгагдсан, бүртгэсэн өдөр зэргийг тодорхой тэмдэглэнэ.

7.3.Гэрээт компани болон түүний ажилтан нь тоног төхөөрөмжийн бүртгэлийг ажлын үедээ ашиглаж болох бөгөөд компанийн ерөнхий механикт үйл явцыг мэдээлж байна.




7.4.Энэ журмын үүрэг болгосон болон хориглосон аливаа заалтыг зөрчсөн ажилтан, албан тушаалтанд Монгол Улсын холбогдох хууль, Компанийн Хөдөлмөрийн дотоод журам, Хөдөлмөрийн гэрээнд заасан хариуцлагыг хүлээлгэхийн зэрэгцээ Компанид учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх хүртэл арга хэмжээ авна.

--- оОо ---

Хавсралт-1. Өргөх тоног төхөөрөмжийн үзлэг шалгалтын давтамж.

Төхөөрөмж	Шалгалтын давтамж	Шалгалтын төрөл
Бүх өргөх төхөөрөмж	Эхний шууд үзлэг	Бүх ТТ-ийг уурхай дээр анх авчирч байгаа бол хүлээн авахаас өмнө мэргэжлийн хүн үзэж шалгана.
Кран	Жил бүр эсхүл эвдрэл, гэмтэл гарсан байж магадгүй үед	Мэргэжлийн хүн бүтцийн болон механикийн шалгалт хийнэ (мөн бүх троссыг давхар үзнэ).
	3 сар тутам	Мэргэжлийн үнэмлэх гэрчилгээтэй, эрх бүхий оператор үзэж шалгана.
	Ашиглалт бүрийн өмнө	Оператор нь Шалгах хуудсаар эсвэл ажлын өмнө үзнэ.
Өргөгч тавцан, Машины кран, Хүн өргөх кабин, Тусгай өргөх төхөөрөмж	Жил бүр эсхүл эвдрэл, гэмтэл гарсан байж магадгүй үед	Мэргэжлийн эрх бүхий ажилтан бүтцийн болон механикийн шалгалт хийнэ.
	6 сар тутам	Мэргэжлийн үнэмлэх гэрчилгээтэй, эрх бүхий оператор үзэж шалгана.
	Ашиглалт бүрийн өмнө	Оператор нь Шалгах хуудсаар эсвэл ажлын журналаар ажил эхлэхийн өмнө үзнэ.
Гүүрэн болон Боомтын кран	Жил бүр эсхүл эвдрэл, гэмтэл гарсан байж магадгүй үед	Мэргэжлийн ажилтан бүтцийн болон механикийн шалгалт хийнэ (мөн бүх троссыг бас үзнэ).
	6 сар тутам	Мэргэжлийн үнэмлэх гэрчилгээтэй, эрх бүхий оператор үзэж шалгана.
	Ашиглалт бүрийн өмнө	Оператор нь Шалгах хуудсаар эсвэл ажлын журналаар ажил эхлэхийн өмнө үзнэ.
Данхраад болон Машин өргөгч	Жил бүр эсхүл эвдрэл, гэмтэл гарсан байж магадгүй үед	Мэргэжлийн ажилтан бүтцийн болон механикийн шалгалт хийнэ.
	Хэрэглэхийн өмнө	Мэргэжлийн үнэмлэх гэрчилгээтэй, эрх бүхий ажилтан шалгана.
Гар ажиллагаатай өргөх төхөөрөмж	Жил бүр эсхүл эвдрэл, гэмтэл гарсан байж магадгүй үед	Мэргэжлийн ажилтан бүтцийн болон механикийн шалгалт хийнэ.
	Хэрэглэхийн өмнө	Мэргэжлийн үнэмлэх гэрчилгээтэй, эрх бүхий ажилтан шалгана.
Өргөх механизм	Жил бүр	Мэргэжлийн ажилтан шалгана.
	Хэрэглэхийн өмнө	Мэргэжлийн үнэмлэх гэрчилгээтэй, эрх бүхий ажилтан шалгана.

Хавсралт-2. Ачааг оосорлоход анхаарах зүйлс.




Хэрэв энэ өнцөг $<45^\circ$ бол,
 $ААХ=ААХ(нэг босоо татлага) \times A/B$

Хавсралт-3. Татлаганы татах чиглэлээс хамаарч даац өөрчлөгдөх нь.

ТРОСС Ø	ТАТАХ ЖИН			Дугуй хэлбэрт ачаа			Тэгш өнцөгт ачаа			2,3 ба 4 салаа татлага		
	шулуун	дугуй	тэгш өнцөгт	0°	60°	90°	0°	60°	90°	0°-60°	90°	120°
8	0.55	0.41	0.27	1.09	0.94	0.77	0.55	0.48	0.39	0.94	0.77	0.55
9	0.69	0.52	0.34	1.38	1.19	0.97	0.69	0.60	0.49	1.19	0.97	0.69
10	0.85	0.64	0.43	1.70	1.47	1.20	0.85	0.74	0.61	1.47	1.20	0.85
11	1.03	0.77	0.52	2.10	1.78	1.45	1.03	0.90	0.73	1.78	1.45	1.03
12	1.23	0.92	0.61	2.50	2.10	1.73	1.23	1.07	0.87	2.10	1.73	1.23
13	1.44	1.08	0.72	2.90	2.50	2.00	1.44	1.25	1.02	2.50	2.00	1.44
14	1.67	1.25	0.83	3.30	2.90	2.40	1.67	1.45	1.19	2.90	2.40	1.67
16	2.20	1.64	1.09	4.40	3.80	3.10	2.20	1.90	1.55	3.80	3.10	2.20
18	2.80	2.10	1.38	5.50	4.80	3.90	2.80	2.40	1.87	4.80	3.90	2.80
20	3.40	2.60	1.70	6.80	5.90	4.80	3.40	3.00	2.40	5.90	4.80	3.40
22	4.10	3.10	2.10	8.30	7.10	5.80	4.10	3.60	2.90	7.10	5.80	4.10
24	4.90	3.70	2.50	9.80	8.50	6.90	4.90	4.30	3.50	8.50	6.90	4.90
26	5.80	4.30	2.90	11.5	10.0	8.10	5.80	5.00	4.10	10.0	8.10	5.80
28	6.70	5.00	3.30	13.4	11.6	9.40	6.70	5.80	4.70	11.6	9.40	6.70
32	8.70	6.50	4.40	17.4	15.1	12.3	8.70	7.60	6.20	15.1	12.3	8.70

Ажлын Аюулгүйн Хязгаар (ААХ) нь троссыг яаж хэрэглэснээс хамаарна. Татах өнцөг (зурагт үзүүлсэн) нь хурц болох тусам троссны даац буурна. Дараагын зургаас 1000 кг даац яаж буурч байгааг хар. Даац нь татах өнцөг их буюу 90° байхад хамгийн их байх бөгөөд 30° үед хамгийн бага байна.



3 салаа нь 2 салаа татлаганаас, хүндийн төв нь тэгш хуваарилагдсан үед 50% илүү даацтай. 4 салаа татлага нь тогтворыг нэмэгдүүлэх боловч даацыг өсгөхгүй.

ӨНЦӨГ	90°	85°	80°	75°	70°	65°	60°	55°	50°	45°	40°	35°	30°
ДААЦ %	100	99.6	98.5	96.6	94.0	90.6	86.6	81.9	76.6	70.7	64.3	57.4	50.0

Хавсралт-4 Өргөх зөөх үйл ажиллагаа

